

“СИЛИКАТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ.

2024 он 03 сарын 11.

№ 02.

Дархан-Уул аймаг.

“Силикат”ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурал“Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай” асуудлыг авч хэлэлцэн, олонхийн саналыг үндэслэн

ТОГТООХ НЬ:

1. “Силикат” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 сарын 25-ны өдрийн 10 цагт “Силикат” ХК-ийн өөрийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.
 - Компанийн санхүүгийн тайлан, Хараат бус аудитын дүгнэлт, тайлан.
 - Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө.
 - Компанийн нэрийг өөрчлөн Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани болгох, нэгж хувьцааг эргүүлэн худалдаж авах
 - ТУЗ-ийн төсөв.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай мэдэгдэлийг СЗХороо, МХБирж-д мэдэгдэх өдрийг 2024 оны 03 сарын 13-ний өдрөөр тогтоон хурлын мэдэгдэлийг тухайн өдөр МХБиржийн цахим хуудсанд байршуулахыг В.Мөнхтамирт даалгасугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах тухай зарыг өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлд 2 удаагийн давтамжтайгаар хэвлүүлэн хувьцаа эзэмшигчидэд мэдэгдэх өдрийг 2024 оны 03 сарын 15 болон 03 сарын 29-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерийн компанид хурлын танилцах материалыг 2024 оны 03 сарын 20-ны өдөр хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 03 сарын 30-ны өдрөөр тогтоосугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг 02 дугаар хавсралтаар, ээлжит хурлын мэдэгдэлийг 03 дугаар хавсралтаар эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах саналын хуудасны загварыг 04 дүгээр хавсралтаар тус тус баталсугай. -02 дугаар хавсралтаар баталсан танилцах бичиг баримттай 2024 оны 03 сарын 30-ны өдрөөс 2024 оны 04 сарын 15-ний хооронд “Силикат”ХК-ийн байранд ирж танилцах эрхтэй болохыг дурьдсугай.
7. Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдрийн буюу 2024 оны 04 сарын 25-ны өдрийн10 цагаар тогтоосугай.

